



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

Зохион байгуулалтын арга  
хэмжээ авч ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээний төлбөрийг төр хариуцахтай холбогдуулан, өвлийн их ачаалал дуусах хүртэлх хугацаанд эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудыг өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллуулсугай.

2.Эрчим хүчний нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн системүүдийн найдвартай ажиллагааг хангуулах, өвлийн их ачааллыг хүндрэлгүй давах, үйлдвэр, компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар шуурхай хангах, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу байгуулсугай.

3.Ажлын хэсэг дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

а.Цахилгааны ачааллын өсөлттэй холбогдуулан онцгой үеийн горим ажиллагааг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

б.Нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн системүүдийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

в.Цахилгаан, дулааны ачаалал, хэрэглээ, горимын талаарх мэдээллийг батлагдсан маягтын дагуу өдөр бүр авч, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих;


4.Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллахтай холбогдуулан үйлдвэр компаниуд эргүүл, жижүүр, шуурхай ажиллагааны бригадыг томилох, болзошгүй гэнэтийн шаардлагатай үед ашиглалт, засварын нэгжийн инженер техникийн ажилтан, ажилчдыг орлон ажиллах схем гарган бэлэн байдлыг хангаж ажиллахыг үйлдвэр, компаниудын гүйцэтгэх захирал, ерөнхий инженер нарт үүрэг болгосугай.

5.Эрчим хүчний яамны хариуцлагатай жижүүрийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар, ажиллах удирдамжийг гуравдугаар хавсралтаар, үйлдвэр, компаниудын үйл ажиллагааны хяналтын үндэслэл, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих;

6.Хариуцлагатай жижүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, жижүүрийн тайланг 7 хоног бүрийн Баасан гарагт удирдлагуудад танилцуулж байхыг Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Батзориг/-т, халдвар, хамгаалал, ариутгал, техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Х.Бекболат/-т тус тус үүрэг болгосугай.

7.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Насантогтох/-д даалгасугай.

САЙД



Н.ТАВИНБЭХ